





ШАЛТГААНЫ УТГАТАЙ УНӨ-ИЙН БҮТСЭН АРГЫГ ТОДОРХОЙЛОХ

VIII анги

Хичээлийн зорилго

- Өгүүлбэрүүдийг утга, бүтцээр нь ялгах, таних
- Шалтгааны утгат нийлмэл өгүүлбэрийн талаар мэдэх
- Шалтгааны утгат өгүүлбэрийг найруулгад хэрэглэх

Өгүүлбэр



Энгийн өгүүлбэр

- Нэг үйл явдлыг нэрлэнэ.
- Нэг үйл явдлын тухай санааг илтгэнэ.
- Гол ба гол бус гишүүдээс бүтнэ.
- Нэрийн нөхцөлөөр холбогдоно.
- Өгүүлбэрийн гол гишүүд

Нэр үг $\longleftrightarrow$ үйл үг

Нэр үг = нэр үг

Ижил тал

- Үйл явдлыг өгүүлнэ.
- Санааг илэрхийлнэ.
- Харилцах хэрэглүүр болно.
- Гишүүдээс бүтнэ.
- Хэлзүйн холбоосоор холбогдоно.

Нийлмэл өгүүлбэр

Хоёр ба түүнээс дээш үйл явдлыг нэрлэнэ.

Харьцангуй цогц санааг илтгэнэ.

- Гол ба гол бус гишүүн өгүүлбэрээс бүтнэ.

- Үйлийн ба нэрийн нөхцөлөөр холбогдоно.

Гишүүн өгүүлбэр + гол өгүүлбэр

Үйл үг + үйл үг

Үйл үг + нэр үг

Дараах 2 өгүүлбэрийн утга бүтцийг ажиглая.

1. Мазаалай угтаа махчин амьтан.

Энгийн өгүүлбэр

2. Гэвч мазаалай одоо малчдад бэлчээр нутгаа булаалгаж, цөлрүү шахагдсан учраас идэш тэжээлийнх нь 77 хувь ургамал, 23 хувь амьтны гаралтай болсон.

Нийлмэл өгүүлбэр

- Хоёр өгүүлбэрт тус бүр хэдэн санаа илэрч байна вэ?
- Хоёр дахь өгүүлбэрийг хоёр энгийн өгүүлбэр болгон бичээрэй.
- Энэ хоёр өгүүлбэрийн аль нь голлож, аль нь түүнд захирагдсан байна вэ?
- Энэ өгүүлбэрт “учраас” гэдэг холбоо үг ямар үүрэгтэй байна вэ?
- Угсарсан нийлмэл үгтэй ижил шинж байна уу?

Дараах өгүүлбэрүүдийн холбох хэрэглүүрийг олж утгыг тайлбарлая.

- Гэвч мазаалай одоо малчдад бэлчээр нутгаа булаалгаж, цөлрүү шахагдсан учраас идэш тэжээлийнх нь 77 хувь ургамал, 23 хувь амьтны гаралтай болсон.

Мазаалай одоо малчдад бэлчээр нутгаа булаалгаж, цөлрүү шахагдсан **учраас**

Яагаад? Ямар учраас?

Мазаалайн идэш тэжээлийнх нь 77 хувь ургамал, 23 хувь амьтны гаралтай болсон.

- Түүний иддэг ургамал, шавж байгальд ховордсоноос мазаалай өлсөж үхэх болсон.

Түүний иддэг ургамал, шавж байгальд ховорд**соноос**

Яаснаас?

. Мазаалай өлсөж үхэх болсон

- Их ган нүүрлэж, идэш тэжээлгүй болбол зунаар ичээлнэ.

Их ган нүүрлэ**ж**, идэш тэжээлгүй бол**бол**

Яавал? Яагаад?

зунаар ичээлнэ.

- Түүнийг аврахын тулд янз бүрийн тэжээл орлуулан тавьдаг.

Түүнийг аврахын **тулд**

Яагаад?

янз бүрийн тэжээл орлуулан тавьдаг.

Шалтгааны утга бүхий төгс өгүүлбэр нь төгс өгүүлбэртэй нөхцөл болон холбох үг гэсэн 2 аргаар холбогдож байна.

Шалтгааны утгат өгүүлбэр

Нийлмэл өгүүлбэрт үйл явдал дараалж болоход аль нэг нь илүү гол үүрэгтэй байдаг. Эхний үйл явдал нь дараагийн үйл явдал бүтэхийн үндэс болж, **төгс бус өгүүлэхүүнээр** илэрсэн өгүүлбэрийг шалтгааны утгат өгүүлбэр гэнэ. Ийм өгүүлбэр нь **ямар учраас?, юуны учир?, яаж?, яахлаар?, яавал?, яасанд? яаснаас?, юу гэж? юуны тулд? зэрэг** асуултад хариулагдана.

Шалтгааны утгат холбох хэрэглүүр :

- **Нөхцөл** : -тал 4, -бал4, -вал4,- хлаар4 , - нгуут2, -нгаа4, -аад4 , - х, -сан4, -даг4 + нэрийн тийн ялгалын нөхцөл
- **Холбох үг**: учраас, тул, тулд, учир, улмаас, бол...

Жишээ нь: Сүүдэр хар**аад** сүхээ барина

Сүүлээ хар**аад** соёогоо харуулна. Энэ хэлцэд байгаа 2 өгүүлбэрийн аль аль нь хардах, хэрцгий авиртай гэсэн утгатай бөгөөд үйлийн урьдчилан холбох “ – аад “ нөхцөл нь дараах үйл буюу “сүхээ барих”, “соёогоо харуулах” гэсэн үйл бүтэх шалтгааны утга болж байна.

Дараах өгүүлбэрт тохирох холбох хэрэглүүрийг сонгож, шалтгааны утгатай болгож бичээрэй.

1. Мазаалай устаж байгаа амьтан. Шүднээс олонгүй баавгай үлдсэн гэж эрдэмтэд тооцоолжээ.
2. Шувуун дэлэнт эхэд сүү байхгүй . Өөрөө үргэлж өлөн явах юм чинь юугаараа ч сүүших вэ?
3. Говийн байнгын үзэгдэл их ган, ундаалдаг ус булгийг нь ширгээдэг. Тэр ангаж үхнэ.
4. Зарим жил тэндэхийн хөрснөөс зээргэнэ ч цухуйхгүй. Тэр яс мэрсээр байгаад өлбөрч үхдэг.

■**Нөхцөл** : -тал 4, -бал4, -вал4,- хлаар4 , - нгуут2, -нгаа4, -аад4 , - х, -сан4, -даг4 + нэрийн тийн ялгалын нөхцөл

■**Холбох үг**: учраас, тул, тулд, учир, улмаас, бол...

НӨ-үүд хэрхэн холбогдсоныг ажиглаж, шалтгааны утга ямар хэлбэрээр илэрснийг тайлбарлаарай.

❑ Хүчтэй салхи гарахлаар их айлаа шүү.



Хүчтэй салхи гара**хлаар** нөхцөлдүүлэн холбохын дагалдахын “хлаар” нөхцөл нь “**айх**” үйлийн шалтгааныг зааж бна.

❑ Усан дуслыг хураавал сав дүүрнэ.
Уран үгийг цуглуулбал мэргэн болно.



Болзон холбохын –вал, - бал нөхцөл нь “сав дүүрнэ.”, “ мэргэн болно “гэсэн дараагийн үйлийн үүсэх шалтгаан болж байна.

❑ Ишиг эврээ ургахлаар эхийгээ мөргөнө.
Ус эргээ нурахлаар гадагш халина.



Бусдын ач тусыг боддоггүй, ачлалгүй гэсэн гол санаатай бөгөөд дагалдан холбохын -**хлаар** нөхцөл нь **эхийгээ мөргөх, гадагш халих** гэсэн дараагийн үйл үүсэх шалтгаан болж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа